
1. Нууцлалын бодлого

Энэхүү нууцлалын бодлого нь Samsung компани нь таны хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангадаг талаар болон таны хувийн мэдээллийг хэрхэн цуглуулах, ашиглах, хадгалах талаар зохицуулдаг.

Та **www.Bespoke.mn** сайт руу шууд болон өөр сайтаар дамжуулан хандаж, **Cookie** цуглуулахыг зөвшөөрснөөр энэхүү Нууцлалын бодлого-д тусгасан нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч буй хэрэг юм.

1.1. Cookie гэдэг нь:

Cookie нь вэбсайтад зочлох үед таны компьютер эсвэл хөдөлгөөнт төхөөрөмж дээр байрлуулсан жижиг өгөгдлийн файлууд юм. Cookie-г вэбсайт эзэмшигчид вэбсайтаа ажиллуулах, дотоод маркетингаа илүү үр дүнтэй хийхийн тулд тайлагнах мэдээллийг өгөх зорилгоор өргөн ашигладаг.

1.2. Бид ямар зорилгоор cookie ашигладаг вэ?

Та манай вэбсайтаар зочлох үед бид таныг манай вэбсайтад хэрхэн хаанаас нэвтэрч, аль контент, шийдлийг түлхүү сонирхож байгаа зэрэг мэдээллүүдийг анализ хийн эргээд танд тохирсон контент бүтээх, шийдлийг танилцуулах зэргээр дотоод маркетингийн үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулахад ашиглах юм. Мөн та хүссэн үедээ өөрийн хувийн мэдээллээ устгуулах боломжтой.

2. Мэдээлэл цуглуулах, ашиглах

2.1. Бид таны ямар мэдээллийг цуглуулдаг вэ?

www.bespoke.mn цахим хуудсанд хандахад та сайтад бүртгэлтэй байх шаардлагагүй. Харин та бидний санал болгож буй ямар нэгэн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл авах хүсэлт илгээх болон бидний зохион байгуулж буй үйл ажиллагаа, арга хэмжээнд оролцохоор бүртгүүлэх үед тухайн үйлчилгээг танд хүргэхэд шаардлагатай холбогдох мэдээллийг бид танаас цуглуулдаг. Бүртгэлд шаардлагатай мэдээллийг өгөхөөс татгалзах нь танд

бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээлэл хүргэх болон таны арга хэмжээнд оролцох боломжийг хязгаарлах юм.

2.2. Бидний цуглуулдаг мэдээллийн төрлүүд:

- **Холбогдох мэдээлэл:** Таны нэр, байгууллагын нэр, албан тушаал, албан имэйл хаяг, утасны дугаар.
- **Samsung компанийн бүтээгдэхүүнтэй холбоотой мэдээлэл:** Таны санал хүсэлт, асуулт, бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гомдол.

2.3. Бид ямар үед таны хувийн мэдээллийг цуглуулдаг вэ?

Дараах нөхцөлүүдэд бид таны хувийн мэдээллийг цуглуулдаг:

- Samsung компаниас зохион байгуулж буй арга хэмжээнд оролцохоор бүртгүүлэх
- Samsung компанийн зохион байгуулж буй хэлэлцүүлэг, форумд оролцохоор бүртгүүлэх
- Samsung компанийн нийлүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авах хүсэлт ирүүлэх
- Samsung компанитай холбоотой санал хүсэлт, гомдлын талаар мэдээлэл ирүүлэх үед бид таны хувийн мэдээллийг цуглуулж, бүртгэдэг

2.4. Samsung компани нь таны хувийн мэдээллийг хэрхэн ашигладаг вэ?

Бид таны хувийн мэдээллийг хуулийн дагуу бизнесийн харилцаа үүсгэх (“Бизнес Зорилгоор”), тантай гэрээ байгуулах болон хэрэгжүүлэх (“Гэрээний”), зөвшилцөлд хүрэх (“Зөвшилцлийн”), болон хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор (“Хуульд заасан үндэслэл”-ийн дагуу) ашигладаг.

Бид дараах зорилгоор таны хувийн мэдээллийг ашиглана:

- Samsung компанийн санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар танд мэдэгдэх болон дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, Бизнес болон Зөвшилцлийн зорилгоор
- Бидний үйлчилгээний талаарх таны үзэл бодлыг онлайн санал асуулга, хэлэлцүүлгийн форумар дамжуулан асуух, Бизнес болон Зөвшилцлийн зорилгоор
- Танд санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ сайжруулах, Бизнес зорилгоор
- Маркетинг болон борлуулалтын зорилгоор, Бизнес болон Зөвшилцлийн зорилгоор

- Таны хувийн мэдээллийг таних боломжгүй болгон Статистик болон аналитик зорилго бүхий, Бизнес зорилгоор
- Аюулгүй байдлын зөрчил болон луйврыг илрүүлэх, сэргийлэх, шалгах, Бизнесийн болон Хуульд заасан зорилгоор
- Хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд үйл ажиллагаа, хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээгээ илүү сайн нийцүүлэх, Бизнес зорилгоор

Таны мэдээллийг ашиглах эрхийг бид таны зөвшөөрлийн үндсэн дээр эзэмшдэг учир, та хүссэн үедээ цуцлах буюу мэдээллээ устгуулах боломжтой.

- Бид таны мэдээллээр дамжуулан манай цахим хуудсыг хүмүүс хэрхэн ашиглаж байгаа талаар хяналт тавьдаг ба цахим хуудсаа илүү хэрэгцээтэй болгож хөгжүүлэхэд ашигладаг. Ингэхдээ бид зөвхөн таны вебээр зочилсон түүхийг ашиглах ба таны нэр болон бусад танигдах мэдээллүүдийг ашигладаггүй болно.
- Samsung компанийн зохион байгуулж буй арга хэмжээ, санал асуулгад оролцох эсэхээ та сайн дурын үндсэн дээр шийдэх бөгөөд хэрэв та бидний илгээж буй арга хэмжээ, санал асуулгын мэдээллийг авахыг хүсэхгүй байгаа тохиолдолд бид таны хүссэн үед мэдээлэл илгээх тохиргоог зогсоох боломжтой.
- Санал асуулгын мэдээллийг дотоод маркетингийн судалгаанд ашиглах бөгөөд үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготой.

2.5. Та ямар эрхтэй вэ?:

Хуулийн дагуу та өөрийн хувийн мэдээлэлтэй холбоотой тодорхой эрхүүдтэй. Үүнд:

- www.bespoke.mn дээр бидний ашиглаж болох өөрийн мэдээлэлд хандах хүсэлт гаргах,
- Өөрийн мэдээллийг шинэчлэх, засах, хувийн мэдээллээ ашиглуулахыг хязгаарлах, татгалзах, гуравдагч талд дамжуулахаас татгалзах,
- Системээс хувийн мэдээллээ устгуулах хүсэлт гаргах зэрэг багтана.

2.6. Бид таны мэдээллийг гуравдагч талд дамжуулах уу?

Бид таны санал хүсэлтүүдийг шийдвэрлэх, www.bespoke.mn цахим хуудсыг ажиллуулах, бусад бизнесийн үйл ажиллагааны зорилгоор (жишээ нь, маркетинг төсөл хэрэгжүүлэх, дата баазыг хариуцах, имэйлийн үйлчилгээг дэмжих, мэдээлэлд шинжилгээ хийх гэх мэт) бусад компаниуд болон хувь хүмүүстэй гэрээ хийж болно. Мөн бид Samsung компанийн холбоо хамаарал бүхий байгууллагатай таны хувийн мэдээллийг хуваалцаж (жишээ нь, харилцагчийн

талаарх ойлголт, үйлчилгээг оновчтой байлгах зорилгоор) болох ба энэ нь таны хувийн мэдээллийг цуглуулсан зорилгын дагуу байна.

Шүүхийн шийдвэр, зарлан мэдэгдэл, мөрдөх ажиллагаа болон бусад хуулиар зөвшөөрсөн, төрийн эрх бүхий байгууллагаас шаардсан тохиолдолд хувийн мэдээллийг ил болгох ба энэ тухай танд мэдэгдэх болно.

Бид гуравдагч талын маркетингийн зорилгоор мэдээлэл хуваалцдаггүй ба гуравдагч талын өмнөөс аливаа имэйл, смс илгээдэггүй.

Бид худалдах, нэгдэх, удирдлага өөрчлөгдөх, хөрөнгө шилжүүлэх, компанийг дахин зохион байгуулах эсвэл хөрвөх (дахин зохион байгуулах үйл ажиллагаа) үйл ажиллагааны үр дүнд таны хувийн мэдээллийг дахин зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой гуравдагч талд шилжүүлж, худалдаж эсвэл хүлээлгэн өгч болно.

2.7. Бид таны мэдээллийг хэр удаан хадгалдаг вэ?

Бид таны хувийн мэдээллийг бүртгэж авснаас хойш 1 жилийн хугацаанд хадгална. Мэдээлэл хадгалах хугацаа дуусмагц дараах зорилгоор таны хувийн мэдээллийг тодорхой хугацаанд хадгалж болно.. Үүнд:

- Бизнесийн үйл ажиллагааны бүртгэлийг шинжилгээний болон аудитын зорилгоор хадгалах
- Хуулийн дагуу бүртгэл хадгалах шаардлагыг даган мөрдөх
- Хуулийн нэхэмжлэлийг гаргах, хамгаалах, аливаа гомдлыг шийдвэрлэх зэрэг багтана

Эдгээр зорилгоор таны мэдээлэл шаардлагагүй болсон үед бид мэдээллийг бүрэн устгана.

2.8. Мэдээллийн аюулгүй байдал

Бид онлайн горимд хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах зорилгоор SSL нууцлалыг ашиглахын зэрэгцээ дотоод систем дэх хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах үүднээс шаардлагатай арга хэмжээг авч ажилладаг.

Бид хувийн мэдээллийг алдах, буруугаар ашиглах, өөрчлөх, устгахаас хамгаалах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн технологийн стандарт, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хэрэгжүүлдэг. Бид бүх ажилтан, удирдлагуудаа хувийн мэдээллийн нууцлалыг хадгалж, зөвхөн эрх бүхий мэргэжилтнүүд мэдээлэлд хандах эрхтэй байхаар зохицуулдаг.